

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИНД ЗЭВСГИЙН АЛБА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ



Монгол Улсын Зэвсэгт хүчний байлдааны зэвсэг нь мэргэн, буудах сумны дарь нь үргэлж хуурай байх!

МЭНДЧИЛГЭЭ

Зэвсэгт хүчний байлдах чадварын материаллаг үндэс болсон зэвсгийн мэргэжлээр овоглосон эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч байлдагч, ажилчин албан хаагч болон энхийг дэмжих ажиллагаанд зэвсгийн бэлэн байдлыг ханган үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид, Зэвсэгт хүчний зэвсгийн хөгжлийн түүхийг бүтээж буй ахмад дайчид, сонсогч та бүхэнд орчин цагийн Зэвсэгт хүчинд Зэвсгийн алба үүсэж хөгжсөний 101 жилийн ойн мэндийг дэвшүүлье.

Цэрэг хүний хоёр дахь амь болсон зэвсгийн байлдааны бэлэн байдлыг хангаж, хэрхэн зөв ашиглах, цэцэн буудаж сургах талаар зэвсгийн мэргэжлийн бие бүрэлдэхүүн цаг ямагт анхааран ажиллаж ирсэн билээ. Өнөөдөр зэвсгийн мэргэжилтэн бид Зэвсэгт хүчний зэвсэглэлийг шинэчлэн сайжруулах, өөрчлөлт хийх, галт хэрэгсэлийг дотооддоо үйлдвэрлэх нэгэн түүхэн зууныг хамт эхлүүлж байна.

Зэвсэгт хүчний зэвсгийн мэргэжлийн үе үеийн алба хаагчид Зэвсэгт хүчний байлдах чадварыг нэмэгдүүлэх, зэвсэглэлийн хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэхээр зүтгэл гарган ажиллаж байсны дүнд Зэвсэгт хүчний түүхийн бүхий л он цагуудад зэвсгийн бэлэн байдал хангагдсаар ирсэн юм. Бид шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан зэвсэглэлийг сайжруулах, шинийг санаачилж, оновчтой санааг ажил хэрэг болгох, сургалтыг шат дараалсан хэлбэрээр төлөвлөж, бие бүрэлдэхүүний мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж, түүндээ хүрэх болно.

Зэвсгийн мэргэжилтэн та бүхнийг энэ онд зохион байгуулагдах "Зэвсгийн мастерууд 2022" тэмцээндээ амжилттай оролцож, амжилт бүтээлээрээ бусдыгаа манлайлан, сурсан мэдсэнээ анги, салбартаа түгээн ажиллаж, Зэвсгийн албаны нэр хүндийг өндөрт өргөнө гэдэгт гүнээ итгэж байна.

Та бүхэндээ Зэвсэгт хүчинд Зэвсгийн алба үүсэж хөгжсөний 101 жилийн ойн мэндийг хэлтсийнхээ нийт бие бүрэлдэхүүний өмнөөс дахин дэвшүүлж, цаашдын амьдралд тань аз жаргал, эрүүл энх, албанд тань амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН МАТЕРИАЛ, ТЕХНИКИЙН ГАЗРЫН ЗЭВСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ХУРАНДАА П.ЧИНЗОРИГ



МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсгийн мэргэжилтэй үе үеийн ахмад дайчид, одоо алба хааж буй офицер, ахлагч, байлдагч, ажилтан албан хаагч, тус мэргэжлийг эзэмшихээр сурч байгаа сонсогч та бүгдийн амрыг эрье.

"Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбоо" нь 2014 оны 3 дугаар сарын 18-нд анх байгуулагдаж зэвсгийн мэргэжлийн офицер, ахлагч, энгийн ажилтан албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, ахмад үеэ алдаршуулан, залуу үеийнхэндээ мэдлэг, туршлага, чадвараа өвлүүлэн үлдээх үндсэн зорилготойгоор гишүүдийнхээ дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Холбооноос санаачлан БХЯ, ЗХЖШ-ын удирдлагад санал боловсруулан хүргүүлсний үр дүнд 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Батлан хамгаалахын сайдын А/26 дугаар тушаалаар "Зэвсгийн албаны өдөр"-тэй болж, бид эл өдрийг бахархалтайгаар тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай болж байна.

Өнгөрсөн хугацаанд ЗХЖШ-ын МТГ-ын Зэвсгийн хэлтэстэй хамтран багагүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Зэвсэгт хүчний хэмжээнд "Зэвсгийн мастер" цогцолбор тэмцээн тогтмол зохион байгуулагддаг болов. Зэвсгийн мэргэжлийн эрдэмтэд, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, орчин үеийн шинэ техник, технологийг зэвсэглэлийг сайжруулах, шинэчлэхэд хэрэгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, ҮБХИС-д буудлагын зэвсгийн анхны виртуал танхимыг тус мэргэжлээр төгссөн сонсогчид, ахмад багш нарын хандиваар байгуулж, ахмад багш хурандаа Д.Сосорбурамын нэрэмжит болголоо.

Монгол Улсын Зэвсэгт хүчинд "Зэвсгийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойн өдөр"-ийг тохиолдуулан зэвсгийн мэргэжлийн хүнд бөгөөд нэр төртэй албыг итгэл дүүрэн хаасан үе үеийн Зэвсгийн хэлтэс, Зэвсэгт хүчний зэвсгийн мэргэжлийн анги, салбаруудын хамт олон, зэвсгийн мэргэжилтэй ахмадууд болон одоо албаа хааж буй бие бүрэлдэхүүн та бүхний ажил, албанд нь өндөр ажилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Монгол Улсын Зэвсэгт хүчний байлдах буу мэргэн, буудах сумны дарь үргэлж хуурай байх!

МОНГОЛ УЛСЫН "ЗЭВСГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБОО"-НЫ ТЭРГҮҮН БЭЛТГЭЛ ХУРАНДАА Д.БАТБОЛД

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчинд зэвсгийн мэргэжил үүсэн бий болсны 101 жил, дотооддоо Зэвсгийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 30 жилийн түүхт ойг тохиолдуулан их зэвсгээрээ овоглон яваа энэ их айлын тулгын чулууг тавилцан явсан зэвсгийн мэргэжлээр ажиллаж байсан үе үеийн ахмадууд болон өнөөдөр ажиллаж байгаа бүх бүрэлдэхүүндээ өөрийн болон ангийн офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчид, ажилчин албан хаагч нарын өмнөөс "Зэвсгийн мэргэжилтнүүдийн ойн баярын өдрийн халуун мэндийг хүргэе.

Өнөөдөр тус анги нь 1921 оны 7 дугаар сард Ардын журамт цэрэг Богдын хүрээг чөлөөлсний дараа 1921 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын шийдвэрээр ангийн анхны үндэс суурь тавигдаж Богд хаант Монгол Улсын үед байсан цэргийн зэвсгийн газрын складын буу зэвсэг, галт хэрэгсэлийг дансалж бүртгэх, хуваарилж олгох хадгалж хамгаалах асуудлыг тухайн үед "Буу зэвсэг засах газар" эрхэлж байсан бол Ардын хувьсгал ялсны дараагаар өдгөө Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг зэвсэглэл, галт хэрэгсэл, хими, инженерийн эд хэрэгслээр хангах, тэдгээрийг хадгалах, харуул хамгаалалтыг зохион байгуулах, зэвсэглэлд засвар хийх, "Зэвсгийн бага мэргэжил"-ээр хугацаат цэргийн алба хаагчдыг бэлтгэн цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх гэсэн үүрэгтэйгээр 101 дахь жилдээ Зэвсэгт хүчний удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллаж байна.

2021-2022 оны сургуулийн жилд цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Хээрийн хангалтын байрыг хориглон хамгаалахад салбарын ажиллагаа" сэдвээр хамгийн анх удаагаа анги Ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль, тусгай тактикийн хээрийн сургуулийг амжилттай зохион байгууллаа.

Цаашид Зэвсэгт хүчний хөгжил цэцэглэлтэд Зэвсгийн мэргэжилтнүүд түүчээлэх болтугай гээд Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбооны уриа үгээр мэндчилгээгээ дуусгая "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний буудах буу нь мэргэн, буудах сумны дарь нь үргэлж хуурай байх".

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ, ХУВЬСГАЛТ ТЭМЦЛИЙН АХМАД ЗҮТГЭЛТЭН ХУРАНДАА О.СЭРДАРИЙН НЭРЭМЖИТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ ДЭД ХУРАНДАА Д.НЯМГЭРЭЛ



ЗЭВСГИЙН МУНДАГ МЭРГЭЖИЛТЭН БОЛНО ГЭДЭГТЭЭ ИТГЭЛТЭЙ БАЙНА

Юуны өмнө Зэвсэгт хүчний нийт генерал, офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид, нэг онд татагдан мөр зэрэгцэн алхаж байгаа он жавууддаа Зэвсгийн мэргэжилтнүүдийн өдрийн баярын мэндийг хүргэе.

Миний бие зуун жилийн түүхт Зэвсэгт хүчний 015 дугаар ангид алба хааж байгаадаа болон нэгэн зууныг эхлүүлж түүх бүтээлцэж яваадаа туйлын баяртай байдаг. Аавынхаа нэр хүндийг сөвтээхгүйг хичээж амьдарч байсан бол одоо Монгол Улс, Зэвсэгт хүчин тэр дундаа зэвсгийн ангийнхаа нэр хүндийг сөвтээхгүй явахыг эрхэмлэж явах туйлын хариуцлагатай үүрэг надад нэмэгдсэн гэж би хувьдаа бодож байна.

Цэргийн хүнд бие нэг амь бол зэвсэг хоёр дахь амь гэж хэлэлцдэг юм билээ. Тийм ч учраас цэргийн зэвсэглэл, зэвсэглэлтэй харьцах гэдэг нь цэрэг хүнээс маш өндөр хариуцлага, үр чадвар, тэсвэр тэвчээр шаардаж байдаг зүйл юм байна лээ. Энэ ангид алба хааснаараа бид зэвсэг, галт хэрэгсэлтэй зөв харьцах, эвдрэл гэмтлийг засварлах чадварт суралцан өдрөөс өдөрт үр чадвараа нэмэгдүүлсээр байна. Халагдаад явахдаа зэвсгийн мундаг мэргэжилтэн болно гэдэгтээ итгэлтэй байна.

Миний хувьд эх орондоо оруулж байгаа өчүүхэн хувь нэмэр нь эх орныхоо төлөө тангараг өргөх явдал юм. Энд би болоод миний он жавууд амьдралдаа дахин давтагдашгүй хором мөч бүрийг түүх болгон дурсамждаа хадгалж авч байна. Магадгүй 10, 20 жилийн дараа эргээд уулзахад саяхан болсон мэтээр хуучлан инээлдэн ярилцах гэгээлэг ирээдүйг төсөөлөх би дуртай.

Өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж байдаггүй. Байлдагч миний өчигдөр бас өнөөдөр болж байгаа эрхэм он жавууд, дарга нар, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүн та бүхэн маргааштай минь хамтдаа байх эх сайхан Монголынхоо төлөө батлан хамгаалах ариун үйлсдээ зүтгэж алдар гавьяагаа хамтдаа мандуулья гэж хэлэх байна.

Хүндэтгэсэн: Зэвсгийн засвар үйлчилгээний ротын дэд түрүүч Б.АМАРБЯСГАЛАН



ЗОРИЛТУУД

- 1.Удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг үндэслэн албан тушаалтны мэдлэг, дадлага, үр чадварыг дээшлүүлэх замаар ангийн нэгдсэн үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулан төгөлдөржүүлэх,
- 2.Цэргийн сургалт бэлтгэлжилтийг тасралтгүй зохион байгуулж ангийн бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлийн чанар, сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

- 3.Үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, технологийн горимд нийцүүлэн үйл ажиллагааг тасралтгүй эрчимтэй явуулан бүтээгдэхүүн гаргах;

- 4.Ангийн бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах замаар цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажлын байрны тав тухтай орчин бүрдүүлэх.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)